

## ДЭЛХИЙН ХУРИМТЛАЛЫН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛНЭ

Жил бүрийн 10 дугаар сарын 31-ний өдрийг Дэлхийн хуримтлалын өдөр болгон тэмдэглэдэг уламжлалтай билээ. Энэ жилийн хувьд тус өдрийг хэрхэн өргөн хүрээнд, үр дүнтэй зохион байгуулах асуудлаар Монголбанк, ХБНГУ-ын Хадгаламжийн банкны олон улсын хамтын ажиллагааны сан, МБХ-ны Маркетингийн мэргэжлийн зөвлөл хамтарсан уулзалт хийлээ.



Монголбанкны зүгээс Дэлхийн хуримтлалын өдрийг салбарын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх нь хуримтлал үүсгэх сэдлийг бий болгох, хадгалах дадал суулгахад чухал ач холбогдолтойг онцолж, энэхүү өдрийг хүлээдэг, хадгаламж нээлгэдэг, баярын өдөр байлгахыг зорьж буйгаа илэрхийллээ. Хадгаламжийн үйлчилгээг зөвхөн банкууд үзүүлдэг тул банкуудыг уг аянд идэвхтэй оролцохыг уриалсан юм. Түүнчлэн Хадгаламжийн даатгалын корпорациас аяныг дэмжиж 2 дахь удаагаа оролцохоо илэрхийлэв. Хуримтлалыг нэмэгдүүлэх нь Монголбанкны урт хугацааны зорилтуудын нэг төдийгүй Монгол Улсын зорилттой нийцэж байгаа тул аянд оролцогчид нэгдэж ажиллахыг онцоллоо. Монголбанкны статистик мэдээллээс харахад 2017 оны 11, 12-р сард иргэдийн нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлттэй байсан нь Дэлхийн хуримтлалын өдрийг салбарын хэмжээнд тэмдэглэдэг болсны ач тус хэмээн дүгнэсэн юм.



2018 оны хувьд Дэлхийн хуримтлалын өдрийг тэмдэглэхдээ аян хэлбэрээр тодорхой хугацааны туршид үргэлжлүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд энэ хүрээнд Улаанбаатар хот төдийгүй орон нутагт тодорхой ажлууд зохион байгуулагдах болно.

## ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ЭРХ ОЛГОХ СУРГАЛТ ОРОН НУТАГТ ЯВАГДАЖ БАЙНА

Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Банкны Холбоо хооронд 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдөр “Сургалт зохион байгуулах гэрээ” байгуулагдсан бөгөөд тус гэрээний дагуу Монголын Банкны Холбооноос даатгалын зуучлалын эрх олгох сургалтыг хариуцан зохион байгуулахаар болсон юм.

RESEARCH


**MBA DAILY  
REVIEW**

ӨДӨР БҮР


**Банкны салбарын  
ТОЙМ**

УЛИРАА БҮР


**ХУРАЛ УУЛЗАЛТ  
СУРГАЛТЫН  
ЗОРИУЛАЛТТАЙ  
ТАНХИМУУДЫГ ТҮРЭЭСЛЭН  
ХАМТАРЧ АЖИЛЛАНА**

**Дэлгэрэнгүй мэдээллийг  
11-32 35 81 99081142**



Энэхүү гэрээний хүрээнд даатгалын зуучлалын үйлчилгээ үзүүлж буй арилжааны банкууд ажилтнуудаа сургалтанд хамруулах, Санхүүгийн зохицуулах хорооны шалгалтанд тэнцсэн тохиолдолд тухайн эрх бүхий ажилтнаар дамжуулан даатгалын бүтээгдэхүүнийг зүүчлах боломжтой болж байгаа юм.

Санхүүгийн зохицуулах хороотой хамтран тогтоосон хуваарь ёсоор 2018 оны 9 сарын 9-ний өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд 21 аймгийн 600 гаруй ажилтанд даатгалын зуучлалын сургалт явуулж, шалгалт авахаар төлөвлөөд байна.



Одоогийн байдлаар баруун бүсийн аймгуудын сургалт явагдаж байгаа ба өнөөдөр сургалтын баг Говь-Алтай аймагт ажиллаж байна.

Сургалтыг зохион байгуулахад идэвхтэй хамтран ажиллаж буй Даатгалын зуучлалын мэргэжлийн зөвлөлийн гишүүдэд талархал илэрхийлье.

## АЗИЙН БАНКНЫ ХОЛБООНЫ ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗАЛАА

Азийн Банкны Холбоо (АБХ)-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Эрнест Лин, Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Амадор Хонрадо, ахлах мэргэжилтэн Вэнди Янг нар Монгол Улсад хүрэлцэн ирж МБХ-ны гүйцэтгэх захирал Ж.Унэнбаттай уулзлаа.



Тус уулзалтаар хоёр байгууллагын цаашдын хамтын ажиллагааны боломжуудыг ярилцсан бөгөөд АБХ-ноос МБХ болон гишүүн байгууллагуудыг 11-р сард Малдив улсад зохион байгуулагдах 35 дугаар чуулга уулзалтад урьсаны сацуу ирэх 2-3 жилд АБХ-ны чуулга уулзалтыг Улаанбаатар хотноо дахин зохион байгуулах хүсэлтэй буйгаа илэрхийлсэн юм.

**ОНЦЛОХ**

**ШИНЭЛЭГ**  
МБХ-ны үйл ажиллагаануудын талаархи мэдээ, мэдээллийг байнгын дэлгэцтэй цаг алдалгүй өөрийн гар утаснаас авч ашиглаж болно.

**ХҮРТЭЭМЖТЭЙ**  
МБХ-ноос зохион байгуулсан, зохион байгуулж буй болон эдгээг зохион байгуулахад арга хэмжээнд, үйл ажиллагаанд оролцож, оролцоогүй мэдээллийг илгэе дараас авч болно.

**ХЭРЭГЛЭЭНД НИЙЦСЭН**  
Үйл ажиллагааны талаар санал илгээж, асуулт тавин, арга хэмжээ уриалж, эн ажилд оролцож буй мэдээллийг мөрт өдөрлөх, талархал илэрхийлж, арга, ажиллагааг байгууллагуудтай хамт зохионо.

**БАЙГАЛЬД ЭЗЭЛТЭЙ**  
Зохион байгуулахад буй арга хэмжээтэй холбоотой материал, мэдээллийг цаас ашиглагчийг авч, хэргэлж болно.

iOS Scan this code & download your phone

Android Scan this code & download your phone



Түүнчлэн 2 байгууллага хамтын ажиллагааны хүрээнд банкны сургалт, богино хугацааны хөтөлбөрийг зохион байгуулж, гишүүн байгууллагуудын ажилтнуудын үр чадварыг дээшлүүлэхэд хамтран ажиллах боломжийн талаар ярилцлаа.

МБХ нь АБХ-ны гишүүн байгууллага бөгөөд АБХ-ны 30 дугаар чуулганыг “Ази тив: Дэлхийн эдийн засгийн өсөлтийн хөдөлгүүр” нэрийн дор 2013 онд Монгол Улсад анх удаа амжилттай зохион байгуулсан юм.

## МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА

Мэдээллийн аюулгүй байдлын мэргэжлийн зөвлөлийн ээлжит уулзалт 2018 оны 8-р сарын 30-ны өдөр зохион байгуулагдаж, цаг үеийн асуудлаар ярилцлаа. Уулзалтын үеэр Голомт банкны Мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн захирал О.Батцэнгэл аюулгүй байдлыг хангах талаар түршлагаасаа хуваалцлаа.



Сүүлийн үед хакерууд хамгаалалт өндөртэй банкуудыг бус, харилцагчдыг онилж, хууль бусаар мэдээлэл олж авах, түүнийгээ дамлан худалдах цаашилбал залилан, луйврын зорилгоор ашиглах байдал нэмэгдсээр байгаа тул харилцагчдыг сургах, аюулгүй байдлын мэдлэг олгоход банкууд хамтарч ажиллах шаардлагатай байгаа талаар ярилцлаа. Нэг хүн хэд хэдэн банкны харилцагч байх нь түгээмэл байдаг тул банк бүрийн харилцагчдад зориулсан аюулгүй байдлын зөвлөмж нь ижил стандарттай байвал хэвшил болох боломжтой гэж дүгнэлээ.



Мэргэжлийн зөвлөлийн зүгээс аюулгүй байдлын зөвлөмжийг бүтээгдэхүүн тус бүрээр боловсруулж, бусад банк, холбогдох газар, хэлтсүүдэд хүргүүлэн ажиллах юм.

## ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ УУЛЗАЛТ БОЛЛОО

Даатгалын зуучлалын мэргэжлийн зөвлөлийн ээлжит хурал 2018 оны 8 сарын 15-ны өдөр Хаан банкны Хан тауэр байранд амжилттай зохион байгуулагдлаа. Уулзалтын үеэр даатгалын зуучлалын сургалтыг орон нутагт зохион байгуулахтай холбоотой зохион байгуулалтын ажлуудыг төлөвлөн ярилцав. Энэ сургалтыг зохион байгуулсанаар Улаанбаатар, орон нутгийн 500 гаруй нэгж даатгалын зуучлалын үйлчилгээ явуулах боломжтой болох юм.



Уулзалтын үеэр мэргэжлийн зөвлөлийн 2018 оны 4 дүгээр улиралд хийх ажлуудаа төлөвлөн ярилцлаа. Төлөвлөгөөний дагуу даатгалын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой ажлуудыг хийх бөгөөд Монголын Даатгалын Холбоотой хамтран хэд хэдэн ажлуудыг хамтран зохион байгуулах юм.

## "ИТГЭЛ - НАЙДВАР - БОЛОМЖ" МАРАФОН ЗОХИОН БАЙГУУЛАГДАНА

2015 оноос хойш тасралтгүй зохион байгуулагдаж буй "Итгэл - Найдвар - Боломж" Улаанбаатар 2018 марафон гүйлтэнд оролцох буюу #AchillesChallenge-д нэгдэж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үйлсэд хувь нэмрээ оруулахыг урьж байна.



Энэхүү үйл ажиллагаанаас цугларсан хандив, орлого нь нийгэмд үлгэр жишээ үзүүлэх хөгжлийн бэрхшээлтэй тамирчдыг хөгжүүлэх, тусгай сургуулийн сурагчдыг чадавхижуулах, тэднийг олон улсын тэмцээнд уралдаанд оруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэнэтийн осол, өвчин эмгэгийн дараах нийгмийн нөхөн сэргээлтийг дэмжих зэрэг үйл ажиллагаануудыг санхүүжүүлэхэд зарцуулагддаг.

Энэ удаагийн "Итгэл - Найдвар - Боломж" гүйлт 9 сарын 15-ны Бямба гарагт Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд болно. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас үзнэ үү.

## АЗИЙН БАНКНЫ ХОЛБООНЫ ЭРХЛЭН ГАРГАДАГ "ABA NEWSLETTER" СЭТГҮҮЛИЙН 8 ДУГААР САРЫН ДУГААР ГАРЛАА

Монголын Банкны Холбоо нь Азийн Банкны Холбооны гишүүн байгууллагын хувьд олон талаар хамтран ажилладаг. Азийн Банкны Холбооноос 2 сар тутамд цахим хэлбэрээр өөрийн сэтгүүлийг эрхлэн гаргадаг бөгөөд 2018 оны 8 дугаар сарын сэтгүүлийг илгээсэн байна. Хавсралтаас цахим сэтгүүлийг үзнэ үү.

МОНГОЛЫН БАНКНЫ ХОЛБОО

This message contains graphics. If you do not see the graphics, click [here](#) to view the full e-newsletter.

This newsletter was sent to you because you are registered to receive updates and special promotions from MBA. To opt out, click [here](#).